



## “ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү Мэдээллийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Инновэйшн Инвестмент” Хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн мэдээллийн нууцлал, мэдээллийг боловсруулах, эрх бүхий байгууллагууд, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр давтамжийг тодорхойлох, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, мэдээлэлд зөрүү гарсан тохиолдолд түүнийг залруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү Журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.
- 1.3 Компани нь үйл ажиллагаандаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн засаглалын кодексыг дагаж мөрдөнө.
- 1.4 Компани нь мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:
  - 1.4.1. Тухайн мэдээллийн ач холбогдох, Компанийн бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай боловсруулах, шинэчлэх;
  - 1.4.2. Хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон мэдээллийг нийтэд хүргэх шаардлага, ач холбогдолтой нь уялдуулан тогтсон цаг хугацаанд нь олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх;
  - 1.4.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон оролцогч бусад этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
  - 1.4.4. Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой, бүрэн хэмжээтэй байх;
  - 1.4.5. Компанийн бизнесийн эрх, ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх.
- 1.5 Энэхүү Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 1.5.1 “Дотоод мэдээлэл” гэж Хороо болон Хөрөнгийн биржийн журамд заасныг;
  - 1.5.2 “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д болон Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын 3.1-д заасан этгээдийг;
  - 1.5.3 “Мэдээлэл” гэж утга бүхий өгөгдлийг (биет, хэвлэмэл, файлаар, электрон хэлбэрээр эсвэл өгөгдлийн санд байгаа баримт бичиг эсвэл өгөгдөл);
  - 1.5.4 “Мэдээллийг нээлттэй болгох” гэж Компани (Үнэт цаас гаргагч) нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү Журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохдоо өөрийн компанийн болон арилжаа эрхлэх байгууллага (цаашид “Хөрөнгийн бирж” гэх)-ын цахим хуудас, Хорооноос шаардлагатай гэж үзсэн

- тохиолдолд бусад олон нийтийн хэрэгсэл, тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр дамжуулан хүргэхийг;
- 1.5.5 “Мэдээллийн сан” гэж энэхүү журмаар зохицуулагдах хуульд заасан мэдээллийн нэгдсэн ангилал код, индекс, арга зүй, стандартаар ижилтгэсэн баримт бичгийг шаардлагын дагуу цуглуулж, боловсруулж хадгалсан мэдээлэл, өгөгдлийн бүрдлийг;
- 1.5.6 “Тухай бүр мэдээлэх” гэж Компани (Үнэт цаас гаргагч)-ийн үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг өөрийн Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр дамжуулан хүргэхийг;
- 1.5.7 “Хороо” гэж Санхүүгийн зохицуулах хороог;
- 1.5.8 “Хугацаат тайлан” гэж үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг;
- 1.5.9 “Устгах” гэж цахим мэдээлэл, өгөгдлийг мэдээллийн сангаас дахин ашиглах боломжгүйгээр арилгахыг;
- 1.5.10 “Үнэт цаас гаргагч” гэж үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Компанийг.

## 2. МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

- 2.1 Компани нь үйл ажиллагааны явцад цуглуулсан дараах мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах бөгөөд хууль, тогтоомж болон энэхүү журамд заасан үндэслэлээр нийтэд эсхүл гуравдагч этгээдэд мэдээллийг дамжуулна. Үүнд:
- 2.1.1 Хөрөнгө оруулагч, хамтран ажиллагчийн мэдээлэл;
- 2.1.2 Ерөнхий болон нарийвчилсан үйл ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;
- 2.1.3 Хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө оруулалтын дүн, эзэмшиж буй хувьцааны мэдээлэл;
- 2.1.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журамд заасан сэжигтэй үйлдлийг илрүүлэх зорилгоор цуглуулах мэдээлэл;
- 2.1.5 Үйл ажиллагааны хүрээнд олж авсан аливаа нийтэд ил болоогүй мэдээлэл.

## 3. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ

- 3.1 Компаниас боловсруулан гаргаж буй мэдээлэлд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулагчид эсвэл бусад этгээд мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.
- 3.2 Компаниас боловсруулан гаргаж буй мэдээллүүдийг түүний зориулалт, нууцлалын шаардлага зэргийг харгалзан дараах үндсэн ангилалд хуваана. Үүнд:
- 3.2.1 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэл (1-р зэрэглэл);
- 3.2.2 Олон нийтэд зөвшөөрөлтэйгөөр түгээх мэдээлэл (2-р зэрэглэл);
- 3.2.3 Нууц мэдээлэл (3-р зэрэглэл)
- 3.3 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэлд Монгол Улсын зохих хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд тараахыг үүрэг болгосон Компанийн хагас



жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан зэрэг мэдээллүүд буюу дараах мэдээллүүд багтана. Үүнд:

- 3.3.1 Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
  - 3.3.2 Компанийн тухайн салбарт эзэлж буй байр суурь,
  - 3.3.3 Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;
  - 3.3.4 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл;
  - 3.3.5 Компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
  - 3.3.6 Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;
  - 3.3.7 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
  - 3.3.8 Компанийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;
  - 3.3.9 Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан;
  - 3.3.10 Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлсэн талаарх тайлан;
  - 3.3.11 Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс тухай бүр нээлттэй мэдээллэхээр тусгасан мэдээлэл.
- 3.4 Олон нийтэд зөвшөөрөлтэйгөөр түгээх мэдээлэлд Монгол Улсын зохих хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд түгээхээр тогтсон, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүд орно. Үүнд:
- 3.4.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлд нь зогсоосон;
  - 3.4.2 Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх;
  - 3.4.3 Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг өөрчлөгдсөн;
  - 3.4.4 Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
  - 3.4.5 Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 3.4.6 Гүйцэтгэх удирдлагын баг, эрх бүхий албан тушаалтны 20 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
  - 3.4.7 Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдан авах, худалдах;
  - 3.4.8 Компанийн хөрөнгө, өр төлбөр, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ, хэлцэл байгуулах;
  - 3.4.9 Компанийн нийт хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
  - 3.4.10 Компанийн хөндлөнгийн аудитын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 3.4.11 Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулсан тухай мэдээлэл;



- 3.4.12 Компанийн гаргасан нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
  - 3.4.13 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц өөрчлөгдсөн тухай мэдээлэл,
  - 3.4.14 Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
  - 3.4.15 Компани өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болсон тухай мэдээлэл;
  - 3.4.16 Компанийг татан буулгах тухай шийдвэр;
  - 3.4.17 Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон тухай мэдээлэл;
  - 3.4.18 Бусад мэдээлэл.
- 3.5 Энэхүү журмын 3.4-т заасан мэдээллийг олон нийтэд тараах хугацаа, арга замыг Компанийн ТУЗ тогтоох ба Гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хүрээнд мэдээллэх мэдээллүүдийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрөлтэйгөөр нийтэд мэдээллэнэ.
- 3.6 Хуулиар хамгаалагдсан аливаа мэдээллийг нууц мэдээлэл гэх ба тус мэдээллийг шүүх, цагдаа, татвар, хянан шалгагч зэрэг эрх бүхий этгээдээс хууль тогтоомжид заасан үндэслэлээр шаардснаас бусад тохиолдолд мэдээллэхгүй.

#### **4. МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ**

- 4.1 Олон нийтэд нээлтэй ба зөвшөөрөлтэй түгээх мэдээллийг ТУЗ болон Компанийн тухайн асуудлаар харьяалсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, алба, нэгжийн захирал хариуцан гаргаж Гүйцэтгэх удирдлагад болон Гүйцэтгэх удирдлагын тогтоосон мэдээллийг олон нийтэд түгээх эрх бүхий албан тушаалтанд шуурхай хүргэнэ.
- 4.2 Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл гаргасан нэгжийн захирал болон Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлаас эрх олгогдсны дагуу мэдээллийг түгээсэн ажилтан хариуцах бөгөөд Компанийн дотоод хяналт хариуцсан нэгж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хяналт тавина.
- 4.3 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, комплайнсын ажилтан нь энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг тухай бүр холбогдох эрх бүхий байгууллагад болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.4 Мэдээлэл боловсруулагч болон олж авсан ажилтан, хувь хүн нь мэдээллийг энэхүү журамд заасан нөхцөл, хугацаагаар нийтэд мэдээллэх хүртэл мэдээллийн нууцлалыг хариуцан ажиллах үүрэгтэй.

#### **5. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

- 5.1 Мэдээллийг холбогдох нэгж буюу нэгжийн хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба компанийн цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэнэ.
- 5.2 Компанийн Хугацаат тайланд хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд Хорооны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ийн хавсралт “Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны



тайлан гаргах”, Хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчийн цахим тайлан ирүүлэх заавар” зэрэг загварын дагуу олон нийтэд мэдээлнэ.

- 5.3 Хугацаат тайлангийн мэдээллийг бүрдүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг компанийн мэдээллийн ажилтан хариуцан ажиллах бөгөөд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаандаа олон нийтэд хүргэж ажиллахад компанийн удирдлага дэмжлэг үзүүлж ажиллана.
- 5.4 Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 7 дугаар сарын 31-ний өдрийн дотор өөрийн Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ.
- 5.5 Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 2 дугаар сарын 28-ны өдрийн дотор өөрийн Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 5.6 Хэрэв Компанийн хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нийтэд мэдээлэхээс өмнө компанийн ашиг, алдагдалын хэмжээ нийтэд ил болсноос үүдэн Компанийн гаргасан үнэт цаасны үнэ ханшийг 15 хувь өөрчлөгдөхөд хүргэсэн бол компани тухайн тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн талаар нэн даруй нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.
- 5.7 Компанийн үйл ажиллагааны тайланд компанийн засаглалын тайлан, компанийн засаглалын кодексийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар заавал тусгасан байна.
- 5.8 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээллүүдийг компанийн цахим хуудсанд байршуулсан хугацаанаас хойш 5 жил хадгалах боломжтойгоор программ хангамжийг тохируулсан байна.

## **6. ТУХАЙ БҮР НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ**

- 6.1 Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг тухай бүрт Компанийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 6.2 Компаниас тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба эдгээрийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаа дамжуулан нийтэд мэдээлнэ:
  - 6.2.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
  - 6.2.2 Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
  - 6.2.3 Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
  - 6.2.4 Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
  - 6.2.5 Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
  - 6.2.6 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;



- 6.2.7 Нийт ажиллагсадын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
  - 6.2.8 Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах;
  - 6.2.9 Үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
  - 6.2.10 Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;
  - 6.2.11 Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
  - 6.2.12 Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
  - 6.2.13 Компани нь хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлт, хөндлөнгийн аудиторыг хугацаанаас нь өмнө сольсон талаарх мэдээлэл;
  - 6.2.14 Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл;
  - 6.2.15 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;
  - 6.2.16 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
  - 6.2.17 Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцааны өөрчлөлт;
  - 6.2.18 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл;
  - 6.2.19 Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдөх;
  - 6.2.20 Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр;
  - 6.2.21 Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч үнэт цаас гаргагчийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
  - 6.2.22 Компанийг өөрчлөн байгуулах шийдвэр;
  - 6.2.23 Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр;
  - 6.2.24 Компани өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болох;
  - 6.2.25 Компанийг татан буулгах шийдвэр;
  - 6.2.26 Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, болон бусад эрх бүхий албан тушаалтнууд холбогдох болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
  - 6.2.27 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр;
  - 6.2.28 Үнэт цаасны ханшид нөлөөлөх бусад шийдвэр, мэдээлэл;
  - 6.2.29 Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.
- 6.3 Компани нь энэхүү Журмын 6.1, 6.2-т заасан мэдээллийг нээлттэй болгохдоо Хороо, Хөрөнгийн биржид тухайн асуудлаар гарсан албан ёсны шийдвэрийг ажлын 1 өдөрт багтаан хүргүүлнэ.



- 6.4 Энэхүү Журмын 6.2-т заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавих этгээд нь гүйцэтгэх захирлын томилсон ажилтан ба гүйцэтгэх захирал компанийн тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
- 6.5 Компанийн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авна:
- 6.5.1 Энэхүү Журмын 6.2-т заасан өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар судалж, холбогдох үндэслэл бүхий тайлбарыг Хөрөнгийн биржид хуанлийн 3 өдөрт мэдэгдэнэ.
- 6.5.2 Компанийн удирдлага тухайн огцом өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлнө гэж үзвэл энэ талаар олон нийтэд ажлын 1 өдөрт багтаан мэдээлнэ.

## **7. КОМПАНИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ**

- 7.1 Компани нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Хороо болон Хөрөнгийн биржийн журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулна.
- 7.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, Компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчид олгох үүрэг хүлээнэ.
- 7.3 Хувьцаа эзэмшигчээс мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан энэхүү журамд хориглоогүй мэдээллийг цахим шуудангийн хаягаар хүргүүлж болно.
- 7.4 Компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.
- 7.5 Компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага энэхүү Журмын 7.4-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавьсан этгээд хариуцна.

## **8. НИЙТЭД МЭДЭЭЛСЭН МЭДЭЭЛЛИЙН АРХИВЫГ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 8.1 Компани нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Хөрөнгийн бирж, Компанийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл 5 жилийн хугацаанд байршина.
- 8.2 Олон нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд тус хугацаа дууссаны дараа тэдгээрийг архивд шилжүүлнэ.



- 8.3 Энэхүү Журмын 8.2-т заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх зэрэг ажиллагааг энэхүү журмын 6.4-т заасан мэдээллийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.
- 8.4 Олон нийтэд нээлттэй түгээсэн мэдээллүүдийн эх хувь, цаасан болон цахим баримтуудыг Компанийн Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бүртгэж хадгална.

## **9. МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХОД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

- 9.1 Дараах этгээдийг Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ. Үүнд:
- 9.1.1. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд буюу хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон үйл ажиллагаа хариуцсан захирлууд,
- 9.1.2. Албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд буюу газар нэгжийн ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч, хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийг тус тус ойлгоно.
- 9.2 Дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү Журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохоос өмнө уг мэдээллийг санаатай болон болгоомжгүйгээр бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 9.3 Дотоод мэдээлэл эзэмшигчид дараах зүйлийг хориглоно:
- 9.3.1 Уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох;
- 9.3.2 Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгох, ятгах;
- 9.3.3 Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамаран Гүйцэтгэх удирдлага болон шууд удирдлагын зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэл цацах, алдаатай, буруу, ташаа, худал мэдээлэл цацах;
- 9.3.4 Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээнэс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах.
- 9.4 Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон бол энэ журмын 9.3-т заасныг зөрчсөнд тооцно.
- 9.5 Компани нь дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийхийг хориглох бөгөөд үүнийг зөрчвөл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авна.
- 9.6 Компани нь дотоод мэдээллийг Хороо болон Хөрөнгийн биржийн тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх ба ийнхүү мэдээлэхдээ Хороо болон Хөрөнгийн биржид мэдэгдэнэ.
- 9.7 Дотоод мэдээллийг дор дурдсан хэлбэрээр нийтэд мэдээлнэ:
- 9.7.1 Үнэт цаас гаргагч, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон Хорооны цахим хуудсаар;



- 9.7.2 Хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх;
- 9.7.3 Тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 9.8 Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

## 10. БУСАД

- 10.1 Мэдээлэл эзэмшигч нь дараах үндэслэлээр мэдээллийг устгах, эсвэл өөрчлөлт оруулна.  
Үүнд:
- 10.1.1 Тухайн мэдээллийг хууль болон журамд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглаагүй бол эрх бүхий албан тушаалтны санаачилгаар;
- 10.1.2 Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр мэдээллийг устгахаар мэдээлэл хариуцагч үүрэг хүлээсэн.
- 10.2 Мэдээллийг тайлагнах, нээлттэй болгоход компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүний нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль журмын дагуу оролцоно.
- 10.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх ба эрх бүхий байгууллага, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.
- 10.4 Энэхүү Журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн, захиргааны, зөрчлийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнд Хөдөлмөрийн хууль, Үнэт цаасны тухай хууль, Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 10.5 Энэхүү Журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг хуулийн хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран буруутай ажилтан, албан тушаалтан нөхөн төлж барагдуулна

ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компанийн жилийн үйл ажиллагааны мэдээлэл, тайлагналтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалын кодекст нийцэж буй байдалд хяналт тавих, бодлого журамд сайжруулалт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ нэмэлт өөрчлөлт оруулж болно

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК**

~oOo~



**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/17

Улаанбаатар хот

**МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 9.6.17 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Инновэйшн Инвестмент ХК-ийн “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмохн/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР